



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/396

Мөрөн сум

Ахмадын асрамжийн байнгын  
үйлчилгээнд хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.2, 19.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын иргэн Шархүүгийн Хүрэлбаатар (УО62070213) нь ах дүү харж хандах боломжгүй, өөрийн гэсэн орон гэргүй, байнгын асаргаанд байх шаардлагатай, ганц бие ахмад настан тул Ахмад настны асрамж үйлчилгээний төвд 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн байнгын асрамжийн үйлчилгээнд хамруулахыг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн дарга (Т.Октябрьбаяр)-д даалгасугай.
2. Тухайн иргэнийг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвд хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулахыг Мөрөн сумын Засаг дарга (Д.Идэрмөнх)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

